



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** СЭА-2022/01/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
	Утас: 7036-3040      Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a>
Сүхбаатар сум 2022 он	Аудитын менежер: Б.Батмөнх
	Утас: 7036-3036      Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a>
	Ахлах аудитор: Т.Болор
	Утас: 7036-2442      Цахим хаяг: <a href="mailto:bolort@audit.gov.com">bolort@audit.gov.com</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал, дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-13
3. Аудитын тайлан	14
3.1. Ерөнхий зүйл	14
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	17
3.4. Материаллаг байдал	17
3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга	17
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	29
3.7. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	33
3.8. Аудитын гол асуудал	35
3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	36
3.10. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	37
3.11. Дараагийн аудитаар анхаарах асуудал	37
4. Аудитын илрүүлэлт	38
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	43

### Товчилсон үгийн жагсаалт

ААТҮГ	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХХ	Аймгийн хөтөлбөрүүдийн хэрэгжилт
БТСГ	Биеийн тамир спортын газар
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДҮАХХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СХС	Сум хөгжүүлэх сан
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭБАТ	Эрх бүхий албан тушаалтан
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА Н. ЛХАГВАДОРЖ ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2022-04-20 № СЭА-2022/01-НА-СТА-ТЭЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>46,133,721.62</b>	<b>67,044,384.59</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	12,801,289.75	28,524,394.67
33	АВЛАГА	15,386,058.04	18,176,793.52
34	УРЬДЧИЛГАА	7,214,723.14	7,247,726.91
35	БАРАА МАТЕРИАЛ	10,725,9721.98	13,037,418.56
36	НӨӨЦИЙН БАРАА	5,678.71	58,050.93
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>257,480,047.59</b>	<b>297,611,610.30</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	257,480,047.59	297,611,610.30
39200	Биет хөрөнгө	239,264,627.09	279,077,061.73
39300	Биет бус хөрөнгө	18,215,420.50	18,534,548.58
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>303,613,769.21</b>	<b>364,655,994.89</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>21,797,025.17</b>	<b>22,383,595.06</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	20,441,720.37	21,612,683.80
41200	Богино хугацаат зээлийн өглөг	394,831.48	373,180.88
41300	Өглөг	17,161,696.92	21,220,539.86
41400	Урьдчилж орсон орлого	2,885,191.97	18,963.07
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,355,304.80	770,911.26
42200	Урт хугацаат зээл	1,355,304.80	770,911.26
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>281,816,744.05</b>	<b>342,272,399.82</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	281,816,744.05	342,272,399.82
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	82,004,195.16	82,982,224.95
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	2,600,250.63	6,938,311.20
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	6,579,150.61	10,414,444.15
51200	Хуримтлагдсан үр дүн	63,662,295.48	112,907,594.05
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	126,970,852.16	129,029,825.46
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>303,613,769.21</b>	<b>364,655,994.89</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>141,949,495.17</b>	<b>184,275,749.69</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>27,296,811.67</b>	<b>34,223,901.07</b>
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>	<b>15,526,133.38</b>	<b>18,390,723.22</b>
1100	Хувь хүний орлогын албан татвар	16,494,114.01	19,175,553.11
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-967,980.63	-784,829.89
<b>113</b>	<b>Хөрөнгийн албан татвар</b>	<b>2,057,813.66</b>	<b>3,412,869.85</b>
<b>118</b>	<b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>	<b>9,712,864.64</b>	<b>12,420,308.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>99,739,402.39</b>	<b>127,622,243.50</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>30,536,406.62</b>	<b>57,069,306.35</b>
<b>121</b>	<b>Хөрөнгийн орлого</b>	<b>82,113.67</b>	<b>177,910.23</b>
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>0.00</b>	<b>180,000.00</b>
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	<b>69,120,882.10</b>	<b>70,195,026.92</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>14,913,281.10</b>	<b>22,429,605.11</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>103,011,165.34</b>	<b>114,756,048.47</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>103,011,165.34</b>	<b>114,756,048.47</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>95,292,197.44</b>	<b>110,091,525.81</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	50,883,413.83	54,160,101.47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,454,949.47	7,050,134.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,447,928.70	9,606,878.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,259,161.12	2,875,855.63
2105	Нормативт зардал	4,209,657.86	4,818,729.88
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	989,762.71	1,322,916.21
2107	Томилолт, зочны зардал	249,378.03	188,550.43
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,624,748.73	10,637,213.14
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,173,196.99	19,431,146.07
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>338,929.10</b>	<b>317,380.10</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,380,038.80</b>	<b>4,347,142.56</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>38,938,329.83</b>	<b>69,519,701.22</b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>307,524.91</b>	<b>891.60</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>22,204,198.36</b>	<b>20,689,110.57</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>17,041,656.38</b>	<b>48,831,482.25</b>

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
<b>1</b>	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>264,548,570.22</b>	<b>0</b>	<b>264,548,570.22</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	679,100.66	0	679,100.66
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	265,227,670.88	0	265,227,670.88
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-336,074.12	0	-336,074.12
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0
7	Өмчид гарсан өөрчлөлт	-116,509.10	0	-116,509.10
8	Зарласан ногдол ашиг	0	0	0
<b>9</b>	<b>Тайлант үеийн үр дүн</b>	<b>17,041,656.38</b>	<b>0</b>	<b>17,041,656.38</b>
<b>10</b>	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>281,816,744.05</b>	<b>0</b>	<b>281,816,744.05</b>
<b>11</b>	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>281,816,744.05</b>	<b>0</b>	<b>281,816,744.05</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,864,744.70	0	2,864,744.70
<b>13</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>284,681,488.75</b>	<b>0</b>	<b>284,681,488.75</b>
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	28,899.41	0	28,899.41
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	97,833.00	0	97,833.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0
17	Өмчид гарсан өөрчлөлт	8,296,280.49	0	8,296,280.49
18	Зарласан ногдол ашиг	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	48,831,482.25	0	48,831,482.25
<b>20</b>	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>342,272,399.82</b>	<b>0</b>	<b>342,272,399.82</b>

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>126,659,773.17</b>	<b>153,875,835.19</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>27,298,980.56</b>	<b>34,223,901.07</b>
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>	<b>15,528,302.26</b>	<b>18,390,723.22</b>
1100	Хувь хүний орлогын албан татвар	16,496,282.89	19,175,553.11
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-967,980.63	-784,829.89
<b>113</b>	<b>Хөрөнгийн албан татвар</b>	<b>2,057,813.66</b>	<b>3,412,869.85</b>
<b>118</b>	<b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>	<b>9,712,864.64</b>	<b>12,420,308.00</b>
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	966,483.40	1,237,434.16
1181	Газрын төлбөр	1,340,878.59	1,979,162.80
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	7,405,502.65	9,203,711.04
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>84,533,014.15</b>	<b>98,500,110.80</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>15,330,018.38</b>	<b>27,947,173.65</b>
<b>121</b>	<b>Хөрөнгийн орлого</b>	<b>82,113.67</b>	<b>177,910.23</b>
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>0.00</b>	<b>180,000.00</b>
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	<b>69,120,882.10</b>	<b>70,195,026.92</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>14,827,778.46</b>	<b>21,151,823.31</b>
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>102,077,762.52</b>	<b>108,988,399.92</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>102,077,762.52</b>	<b>108,988,399.92</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>94,337,046.37</b>	<b>104,231,756.85</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	54,762,306.76	58,977,297.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,808,733.99	7,972,471.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,103,456.11	11,402,785.03
2104	Хангамж, бараа материалын зардал	5,155,307.36	6,631,580.99
2105	Нормативт зардал	4,146,727.50	4,957,260.14
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,006,122.68	1,355,934.63
2107	Томилолт, зочны зардал	247,178.31	184,735.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,134,480.44	4,615,256.85
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,972,733.22	8,134,434.45
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>338,929.10</b>	<b>317,380.10</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,401,787.05</b>	<b>4,439,262.97</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>24,582,010.66</b>	<b>44,887,435.26</b>
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>84,146.36</b>	<b>246,770.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>17,061,275.69</b>	<b>26,951,730.74</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>17,061,275.69</b>	<b>26,951,730.74</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	17,061,275.69	26,951,730.74
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-16,977,129.33</b>	<b>-26,704,960.74</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>-838,333.73</b>	<b>-2,459,369.59</b>
<b>14</b>	<b>Бусад эх үүсвэр</b>	<b>16,329.35</b>	<b>0.00</b>

Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	686,165.00	1,683,500.00
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	168,498.08	775,869.59
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	6,766,547.60	15,723,104.93
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,034,742.15	12,801,289.75
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,801,289.75	28,524,394.67

## 2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт /хэмнэлт	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>111,501,706.00</b>	<b>100,673,977.85</b>	<b>10,827,728.15</b>	<b>90.29</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>90,488,850.30</b>	<b>86,235,682.44</b>	<b>4,253,167.86</b>	<b>95.30</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>87,934,597.80</b>	<b>83,868,357.28</b>	<b>4,066,240.52</b>	<b>95.38</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	53,729,046.20	52,523,124.53	1,205,921.67	97.76
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,188,222.10	6,855,450.11	332,771.99	95.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,337,085.30	9,529,885.86	807,199.44	92.19
2104	Хангамж, бараа материалын зардал	1,715,611.70	1,681,232.57	34,379.13	98.00
2105	Нормативт зардал	2,650,071.50	2,109,928.94	540,142.56	79.62
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,459,154.10	2,378,762.52	80,391.58	96.73
2107	Томилолт, зочны зардал	234,042.80	178,861.56	55,181.24	76.42
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,258,898.00	3,117,555.29	141,342.71	95.66
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,362,466.10	5,493,555.89	868,910.21	86.34
212	<b>ТАТААС</b>	<b>389,508.70</b>	<b>389,508.70</b>	<b>0</b>	<b>100.00</b>
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	72,128.60	72,128.60	0	100.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	317,380.10	317,380.10	0	100.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,164,743.80</b>	<b>1,977,816.45</b>	<b>186,927.35</b>	<b>91.36</b>
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	185,000.00	185,000.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,979,743.80	1,792,816.45	186,927.35	90.56
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>18,538,583.00</b>	<b>12,754,795.41</b>	<b>5,783,787.59</b>	<b>68.80</b>
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>2,474,272.70</b>	<b>1,683,500.00</b>	<b>790,772.70</b>	<b>68.04</b>
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>111,501,706.00</b>	<b>102,660,310.81</b>	<b>8,841,395.19</b>	<b>92.07</b>
31	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>54,627,431.80</b>	<b>53,196,652.08</b>	<b>1,430,779.72</b>	<b>97.38</b>
32	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>50,279,131.70</b>	<b>46,607,379.67</b>	<b>3,671,752.03</b>	<b>92.70</b>
33	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>656,356.30</b>	<b>400,422.53</b>	<b>255,933.77</b>	<b>61.01</b>
35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>4,508,786.20</b>	<b>2,275,856.53</b>	<b>2,232,929.67</b>	<b>50.48</b>
36	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	<b>1,430,000.00</b>	<b>180,000.00</b>	<b>1,250,000.00</b>	<b>12.59</b>
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	3,598,796.85		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	5,586,229.81		
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>38086</b>	<b>100486</b>	<b>-62400</b>	<b>263.84</b>

Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	203	199	4	98.03
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	4573	4555	19	99.60
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	28737	27225	1512	94.74
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	21759	21291	468	97.85
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	6978	5934	1044	85.04
64	ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО	0	63953	-63953	
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	4573	4555	19	99.60

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	Зарцуулах эрх	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>10,010,085.21</b>	<b>10,010,085.21</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>8,926,316.13</b>	<b>8,926,316.13</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>7,438,654.08</b>	<b>7,438,654.08</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,099,770.58	1,099,770.58
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	135,850.19	135,850.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,001.05	34,001.05
2104	Хангамж, бараа материалын зардал	348,150.40	348,150.40
2105	Нормативт зардал	2,850,571.20	2,850,571.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	411,736.98	411,736.98
2107	Томилолт, зочны зардал	4,952.83	4,952.83
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	573,156.39	573,156.39
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,980,464.46	1,980,464.46
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,487,662.05</b>	<b>1,487,662.05</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>770,947.00</b>	<b>770,947.00</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>716,715.05</b>	<b>716,715.05</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,083,769.08</b>	<b>1,083,769.08</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>1,083,769.08</b>	<b>1,083,769.08</b>
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>10,043,553.73</b>	<b>10,043,553.73</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>10,043,553.73</b>	<b>10,043,553.73</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	382,535.85	382,535.85
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	188,201.83	188,201.83
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,570,383.28	3,570,383.28
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,048,889.29	2,048,889.29
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	3,853,543.48	3,853,543.48
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>146,957.28</b>	<b>146,957.28</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	100.00	100.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	33,568.52	33,568.52

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч / цаашид *Аймгийн ТЕЗ гэх/-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.*

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримтын бүрдүүлэлт, хууль тогтоомжийн хэрэгжилт, төсөв захиран зарцуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор, аудитор Д.Чулуунцэцэг, О.Анхбаяр нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Т.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 01/292 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Аймгийн ТЕЗ үйл ажиллагааны эрхэм зорилгыг *“Төрийн үйлчилгээний стандартыг үйл ажиллагаандаа шинэлэг, арга хэлбэрээр хэвшүүлж, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг эрхэмлэнэ.”* гэж тодорхойлон, дараах зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн Хуралд оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах;
- Төрийн болон орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;
- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын

- удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх;
- Нутаг дэвсгэрийнхээ газрыг зүй зохистой ашиглах, газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих, үржил шимийг нь дээшлүүлэх, байгаль орчныг хамгаалах бусад арга хэмжээний цогцолбор хөтөлбөрийг боловсруулж ИТХ-д өргөн мэдүүлэх, батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
  - Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах;
  - Нутаг дэвсгэртээ боловсрол, соёл, эрүүл мэнд, биеийн тамир, спортын талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;
  - Хууль тогтоомж, Засгийн газар, ИТХ, Засаг даргын шийдвэрийг сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах нэх мэт.

Тайлант хугацаанд төсвийн захирагчдын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс шинээр мөрдөгдөхөөр батлагдсан,
- Малын тоо толгойн албан татварын тухай хуультай холбоотойгоор 2020 онд Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 60 дугаар зүйлийн 60.2.8-д малын тоо толгойн албан татварын орлогыг зарцуулах заалт шинээр нэмэгдсэн,
- УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,
- Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 43 дугаар тогтоолоор төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах шаардлагыг төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан,
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах “Босго үнэ шинэчлэн батлах тухай” журмыг баталсан,
- Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” шинэчлэгдэн батлагдсан,

- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” шинэчлэгдэн батлагдсан,
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн,
- Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул гэж дүгнэж байна.

Аймгийн ТЕЗ-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэгдсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж заасны дагуу аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь дотоод хяналтыг хэрэгжүүлж байна.

Тус албанаас 2021 онд хийх хяналт, шалгалтын төлөвлөгөөнд бага, дунд эрсдэлтэй 88 байгууллагад санхүүгийн хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 47 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт, 16 байгууллагад дотоод аудит хийж, нийт 979.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 314.5 сая төгрөгийн төлбөрийн акт, 664.5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгсөн гэж тайлагнасан байна.

Тайлант онд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа нийт 63 байгууллагад дотоод аудит болон санхүүгийн хяналт шалгалт хийж гүйцэтгэснээс 8 байгууллагад төлбөрийн акт тогтоож, 4 байгууллагад албан шаардлага өгсөн бөгөөд өөрөөр хэлбэл хяналт шалгалтад хамрагдсан байгууллагуудын 19.1 хувьд нь алдаа зөрчил илрүүлэн акт, албан шаардлага бичигдэж, 80.9 хувь нь алдаа, зөрчилгүй гэж дүгнэсэн байна.

Тогтоосон актын 69.8 хувь буюу 219.4 сая төгрөгийн актыг төсөвт төвлөрүүлж, албан шаардлагын биелэлтийг 100 хувь биелснээр тайлагнасан байна. Хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож хэвшээгүй байгаа нь ихэнх алдаа, зөрчилд тоон үзүүлэлтгүй зөвлөмж өгдөг тус байгууллагын хувьд шийдвэрийн хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзэх боломжгүй байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны хийж гүйцэтгэсэн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлангаас харахад их хэмжээний мөнгөн хөрөнгийн эргэлт бүхий эрсдэл өндөртэй орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС, СХС зэрэг тусгай сангууд болон аймаг сумдын төсвийн орлого, зарлагын төлөвлөлт, зарцуулалт, худалдан авах ажиллагааг бус сумдын соёлын төв, ИТХ, ойн анги зэрэг төсөв, санхүүжилт, эрсдэл багатай байгууллагууд, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хяналт шалгалт, аудитад хамруулж байгаа нь хяналт шалгалтын үр нөлөө хангалтгүй болохыг харуулж байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 115,133.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 1,151.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 буюу 863.5 сая төгрөгөөр урьдчилан тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга**

#### **3.5.1 Мөнгөн хөрөнгө**

Мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 12,801.3 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 28,524.4 сая төгрөг болж, 15,723.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	6.2	5.4	(0.8)	(14.8)
Банканд байгаа бэлэн мөнгө	12,795.1	28,519.0	15,723.9	55.1
<b>Дүн</b>	<b>12,801.3</b>	<b>28,524.4</b>	<b>15,723.1</b>	<b>55.1</b>
<b>Үүнээс байгууллагын төрлөөр:</b>				
Төсөвт байгууллага	3,520.4	5,542.9	2,022.5	36.5
Төсөл / сан	2,885.2	8,253.3	5,368.1	65.0
Төрийн сан	5,700.9	13,387.9	7,687.0	57.4
ОНӨААТҮГ	694.8	1,340.3	645.5	48.2
<b>Дүн</b>	<b>12,801.3</b>	<b>28,524.4</b>	<b>15,723.1</b>	<b>55.1</b>

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЭЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлд тайлагнагдсан 28,524.4 сая төгрөг нь дараах байдлаар байршиж байна. Үүнд:

- Орон нутгийн өмчит 8 үйлдвэрийн газрын касст бэлнээр 5.4 сая төгрөг,
- Орон нутгийн өмчит 21 үйлдвэрийн газрын харилцах дансанд 1,334.9 сая төгрөг,
- 17 сумын ТТЗ-ийн харьяа байгууллагуудын харилцах дансанд 12,865.8 сая төгрөг,
- Аймгийн ОНӨО-ын дансанд 3,533.5 сая төгрөг,
- Барьцаа хөрөнгийн дансанд 7,908.0 сая төгрөг,
- ОНХС-ийн дансанд 2,876.8 сая төгрөг гэх мэт.

Банканд байршиж буй 28,519.0 сая төгрөгийн үлдэгдлийн 19.4 хувийг төсөвт байгууллагын, 28.9 хувийг төсөл, сангийн, 47.0 хувийг төрийн сангийн, 4.7 хувийг орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн үлдэгдэл тус тус эзэлж байна.

### Төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 12,106.5 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 27,184.1 сая төгрөг болж, 15,077.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн сан	12,106.3	27,182.7	15,076.4	55.5
Арилжааны банк	0.2	1.4	1.2	85.7
<b>Дүн</b>	<b>12,106.5</b>	<b>27,184.1</b>	<b>15,077.6</b>	<b>55.5</b>

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЭЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт **109,143.5** сая төгрөгийн дараах эх үүсвэр төвлөрч, 90,893.3 сая төгрөгийг харьяа байгууллагуудын урсгал зардалд, 10,341.5 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын зардалд, 1,697.7 сая төгрөгийг СХС-ийн зээлийн үйл ажиллагаанд тус тус зарцуулсан байна. Үүнд:

**Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**



- Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 5,226.1 сая төгрөг,
- ОНХС-аас олгох орлогын шилжүүлэг 10,341.5 сая төгрөг,
- БШУЯ-аас тусгай зориулалтын шилжүүлэг 44,168.7 сая төгрөг,
- ЭМЯ-аас тусгай зориулалтын шилжүүлэг 9,328.9 сая төгрөг,
- БХБЯ-аас тусгай зориулалтын шилжүүлэг 559.7 сая төгрөг,
- ХНХЯ-аас тусгай зориулалтын шилжүүлэг 570.1 сая төгрөг,
- Орон нутгийн төсвийн орлого 38,506.1 сая төгрөг,
- Орон нутгийн төсөвт байгууллагын өөрийн орлого 432.4 сая төгрөг,
- Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын өөрийн орлого 10.0 сая төгрөг.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 15,386.1 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 18,176.8 сая төгрөг болж 2,790.7 сая төгрөгөөр буюу 18.1 хувиар өссөн байна.

Хүснэгт №3 Авлагын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	54.6	57.1	2.5
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	335.5	335.5
Татаас, санхүүжилтийн авлага	6.6	944.6	938.0
Зээлийн хүүгийн авлага	278.4	236.2	(42.2)
Дансны авлага /ОНӨААТҮГ/	1,730.0	6,407.5	4,677.5
Татвар, НДШ-ийн авлага /ОНӨААТҮГ/	18.5	46.7	28.2
Бусад авлага	8,294.5	5,245.8	(3,048.7)
Зээлийн авлага	5,003.5	4,903.4	(100.1)
<b>Дүн</b>	<b>15,386.1</b>	<b>18,176.8</b>	<b>2,790.7</b>
<b>Үүнээс байгууллагын төрлөөр:</b>			
Төсөвт байгууллага	7,648.3	6,482.0	(1,166.3)
Төсөл/ сан	135.8	140.6	4.8
Төрийн сан	368.7	315.8	(52.9)
ОНӨААТҮГ	7,233.3	11,238.4	4,005.1
<b>Дүн</b>	<b>15,386.1</b>	<b>18,176.8</b>	<b>2,790.7</b>

*Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЭЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нийт авлагын 59.6 хувийг дараах 4 ОНӨААТҮГ-ын авлага эзэлж байна. Үүнд:

- “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ 6,041.2 сая төгрөг буюу 33.2 хувь, / хуваарийн дагуу төлөх орон сууцны төлбөр/
- “Сэлэнгэ цэнгэг ус” ОНӨААТҮГ 1,849.2 сая төгрөг буюу 10.2 хувь,
- “Сэлэнгэ-Энерго” ОНӨААТҮГ 1,384.1 сая төгрөг буюу 9.0 хувь,
- “Гавшгай ус” ОНӨААТҮГ 1,162.0 сая төгрөг буюу 7.2 хувийг гэх мэт.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай /3-аас дээш жилийн/ нийт 5,043.6 сая төгрөгийн дараах авлагууд байна. Үүнд:

- Төсөвт байгууллага болон ОНӨААТҮГ-ын хувь хүмүүсээс авах 78.4 сая төгрөг,
- Төсөвт байгууллага болон ОНӨААТҮГ-ын байгууллагаас авах 562.3 сая төгрөг,
- ОНӨААТҮГ-ын дансны авлага 1,489.3 сая төгрөг,

- СХС-аас олгосон зээлийн 2,721.4 сая төгрөгийн, зээлийн хүүгийн 177.1 сая төгрөг,
- Төсөвт байгууллагын ажиллагчидтай холбогдсон 12.3 сая төгрөг, татаас, санхүүжилтийн 2.8 сая төгрөгийн гэх мэт.

Олон жилийн насжилттай авлагын 35.3 хувь буюу 27.7 сая төгрөгийг 2008, 2009, 2011 онуудад иргэдэд олгосон итгэлийн зээлийн авлага, 64.7 хувь буюу 50.7 сая төгрөгийг төсөвт байгууллагуудын авлага эзэлж байна.

Олон жилийн насжилттай байгууллагаас авах авлагыг дараах авлагууд эзэлж байна. Үүнд:

- “Сэлэнгэ-Энерго” ОНӨААТҮГ-ын 317.2 сая төгрөгийн авлага 56.4 хувийг,
- “Туулын хишиг” ОНӨААТҮГ-ын 68.6 сая төгрөгийн авлага 12.2 хувийг,
- УТХО-ын 44.6 сая төгрөгийн авлага 7.9 хувийг эзэлж байгаа бол
- 20 төсөвт байгууллагуудын 131.9 сая төгрөгийн авлага нь 23.5 хувийг эзэлж байна.

Дээрх олон жилийн насжилттай авлагуудын зарим эзэн холбогдогчид нь нас барсан, оршин суугаа хаяг тодорхой бус байдлаас болж шүүхэд хандах боломжгүй, зарим авлагын хөөн хэлэлцэх хугацаа дууссанаас шүүхээр шийдвэрлүүлэх боломжгүй болсон байна.

Олон жилийн насжилттай авлагын 53.9 хувь буюу 2,721.4 сая төгрөгийг Сум хөгжүүлэх сангаас 2011-2017 онуудад иргэдэд олгосон зээлийн авлага, 3.5 хувь буюу 177.1 сая төгрөг нь зээлийн хүүгийн авлага байна.

Хэдийгээр СХС-ийн эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн зээлийн мэдээллийг Монгол банкны мэдээллийн санд оруулснаар эргэн төлөлт нэмэгдэж байгаа ч үлдэгдэл их байгаа нь сангийн эх үүсвэр бүрдэхгүй байх, төсвийн хөрөнгө үрэгдэх эрсдэл, үр дагаврыг бий болгож байна.

### **Аудитын илрүүлэлт:**

Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 28 байгууллага 46.2 сая төгрөгийн авлага үүсгэсэн байна. /Хавсралт №1-д дэлгэрэнгүй харуулав./

### **3.5.3 Урьдчилгаа**

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 7,214.7 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 7,247.7 сая төгрөг болж, 33.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	7,214.7	7,247.7	33.0
<b>Дүн</b>	<b>7,214.7</b>	<b>7,247.7</b>	<b>33.0</b>
<b>Үүнээс байгууллагын төрлөөр</b>			
Төсөвт байгууллага	1,690.8	7,234.0	5,543.2
Төсөл/ сан			

**Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Төрийн сан			
ОНӨААТҮГ	5,523.9	13.7	(5,510.2)
<b>Дүн</b>	<b>7,214.7</b>	<b>7,247.7</b>	<b>33.0</b>

*Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Урьдчилгаа дансны үлдэгдэл өссөн нь Ковид-19 цар тахлын улмаас тендер шалгаруулалт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн ажил удааширнаас тайлант онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 6 төсөл, арга хэмжээний 524.2 сая төгрөг, УТХО-аар хэрэгжүүлэх 13 төсөл, арга хэмжээний 4,871.9 сая төгрөг, ОНХО-аар хэрэгжүүлэх 6 төсөл, арга хэмжээний 149.5 сая төгрөгийг тус тус барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн, Сэлэнгэ орон сууц ОНӨААТҮГ-ын төрийн албан хаагчдын орон сууцны барилгыг улсын комиссын актаар хүлээн авч, 5,510.6 сая төгрөгийг зардлаар хүлээн зөвшөөрч, урьдчилгаа данснаас хасаж бүртгэсэн зэргээс голлон шалтгаалсан байна.

### 3.5.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 10,726.0 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 13,037.4 сая төгрөг болж, 2,311.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	747.4	1,019.4	272.0
Эм боох материал	409.2	521.5	112.3
Дуусаагүй үйлдвэрлэл	47.8	18.0	(29.8)
Бэлэн бүтээгдэхүүн	125.8	159.0	33.2
Бичиг хэргийн материал	190.0	226.9	36.9
Аж ахуйн материал	3,610.9	3,823.4	212.5
Сэлбэг хэрэгсэл	1,055.7	988.2	(67.5)
Түлш, шатах тослох материал	45.4	41.5	(3.9)
Барилгын засварын материал	190.0	222.5	32.5
Хүнсний материал	62.6	122.4	59.8
Бусад хангамжийн материал	4,190.4	5,838.3	1,647.9
Биологийн хөрөнгө		7.0	7.0
Мал амьтад	50.8	49.3	(1.5)
<b>Дүн</b>	<b>10,726.0</b>	<b>13,037.4</b>	<b>2,311.4</b>
<b>Үүнээс байгууллагын төрлөөр:</b>			
Төсөвт байгууллага	8,993.6	11,125.3	2,131.7
Төсөл/ сан			
Төрийн сан			
ОНӨААТҮГ	1,732.4	1,912.1	179.7
<b>Дүн</b>	<b>10,726.0</b>	<b>13,037.4</b>	<b>2,311.4</b>

*Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материалын дансны үлдэгдэл 2,311.4 сая төгрөгөөр өссөн нь улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн, дуусаагүй төсөл, арга хэмжээг тус дансанд бүртгэснээс голлон шалтгаалсан байна. Үүнд:

УТХО-аар хэрэгжсэн:

- Баруунбүрэн сумын ЗДТГ-ын барилга барих 135.0 сая төгрөг,
- Сүхбаатар сумын Хүүхэд залуучуудын парк барих 227.5 сая төгрөг,
- Хүүхэд хамгаалал, хөгжлийн төв барих 500.0 сая төгрөг,
- Мандал сумын ахмадын төвийн барилга 400.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ,

Мандал сумын ОНХС, ОНХО-ын хөрөнгөөр хэрэгжсэн:

- Мандал суманд хүүхдийн тоглоомын талбай барих 319.7 сая төгрөг,
- Бохир усны шугам тавих 287.7 сая төгрөг,
- Түнхэл тосгоноос Батсүмбэр сум хүртэлх замыг зураг төсөв 132.0 сая төгрөг,
- Дулааны станцын ТЭЗҮ боловсруулах 79.9 сая төгрөгийн зэрэг нийт 2,081.8 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг бүртгэсэн байна.

### 3.5.5 Нөөцийн бараа

Нөөцийн барааны эхний үлдэгдэл 5.7 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 58.1 сая төгрөг болж, 52.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Нөөцийн барааны үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тэжээлийн нөөц	-	-	-
Бусад нөөц	5.7	58.1	52.4
<b>Дүн</b>	<b>5.7</b>	<b>58.1</b>	<b>52.4</b>

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЭЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Энэ нь Сүхбаатар сумын халаалт, дулааны тогтвортой байдлыг хангах, гэнэтийн гамшгаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Сэлэнгэ-Энерго” ОНӨААТҮГ-ын нөөцөд 58.1 сая төгрөгийн барилгын засварын материал, шатахууны үлдэгдэлтэй тайлагнагдсанаас шалтгаалсан байна.

### 3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 257,480.0 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 297,611.6 сая төгрөг болж, 40,131.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>239,264.6</b>	<b>279,077.1</b>	<b>39,812.5</b>
Барилга, байгууламж, орон сууц	211,554.2	226,837.9	15,283.7
Хуримтлагдсан элэгдэл	(17,013.0)	(23,536.3)	(6,523.3)
Авто тээврийн хэрэгсэл	9,117.0	9,283.7	166.7
Хуримтлагдсан элэгдэл	(5,448.1)	(4,976.8)	471.3
Машин тоног төхөөрөмж	19,660.1	21,566.6	1,906.5
Хуримтлагдсан элэгдэл	(11,834.0)	(10,447.1)	1,386.9

**Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Тавилга, аж ахуйн эд хогшил	8,675.8	8,718.1	42.3
Хуримтлагдсан элэгдэл	(4,640.4)	(4,129.7)	510.7
Зам, гүүрний байгууламж	8,016.7	32,706.6	24,689.9
Хуримтлагдсан элэгдэл	(3,016.9)	(4,055.2)	(1,038.3)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	2,046.0	2,095.9	49.9
Бусад үндсэн хөрөнгө	23,015.6	27,312.2	4,296.6
Хуримтлагдсан элэгдэл	(7,059.2)	(7,943.8)	(884.6)
Дуусаагүй барилга, байгууламж	4,889.1	4,313.5	(575.6)
Ном	1,301.7	1,331.4	29.7
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>18,215.4</b>	<b>18,534.5</b>	<b>319.1</b>
Программ хангамж	267.9	390.7	122.8
Хуримтлагдсан элэгдэл	(133.4)	(147.3)	(13.9)
Бусад биет бус хөрөнгө	18,116.1	18,325.6	209.5
Хуримтлагдсан элэгдэл	(35.2)	(34.4)	0.8
<b>Дүн</b>	<b>257,480.0</b>	<b>297,611.6</b>	<b>40,131.6</b>
<b>Үүнээс байгууллагын төрлөөр:</b>			
Төсөвт байгууллага	182,225.5	197,873.4	15,647.9
Төсөл/ сан	2.8	2.3	(0.5)
Төрийн сан			
ОНӨААТҮГ	75,251.7	99,735.9	24,484.2
<b>Дүн</b>	<b>257,480.0</b>	<b>297,611.6</b>	<b>40,131.6</b>

*Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЭЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Үндсэн хөрөнгө данс /анхны өртгөөр/ тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 3,701.3 сая төгрөг, балансаас баланст шилжүүлэн авсан 8,847.2 сая төгрөг, хандиваар авсан 3,944.8 сая төгрөг, УТХО, аймаг, сумын ОНХО, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 43,100.2 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 1,010.1 сая төгрөг зэрэг нийт 60,603.6 сая төгрөгөөр нэмэгдсэн бол худалдан борлуулсан 19.0 сая төгрөг, балансаас баланст шилжүүлсэн 5,462.6 сая төгрөг, акталсан 7,981.0 сая төгрөг, улсын комиссын актаар 575.6 сая төгрөгийн хөрөнгийг хүлээж авч дуусаагүй барилгын үлдэгдлийг бууруулсан, дахин үнэлгээний хорогдол 343.3 сая төгрөг зэрэг нийт 14,381.5 сая төгрөгөөр буурсан байна.

### 3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 21,797.0 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 22,383.6 сая төгрөг болж 586.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №8 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Богино хугацаат өр төлбөр дүн</b>	<b>20,441.7</b>	21,612.7	1,171.0
<b>Богино хугацаат зээлийн өглөг</b>	<b>394.8</b>	373.2	(21.6)
Арилжааны банк	394.8	373.2	(21.6)
<b>Өглөг</b>	<b>2,875.7</b>	8,664.4	5,788.7
Ажилчидтай холбогдсон өглөг	200.5	260.6	60.1
Бараа үйлчилгээний зардлын өглөг	43.4	303.6	260.2

**Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	3.7		(3.7)
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	2,592.7	8,063.0	5,470.3
Зээлийн хүүгийн өглөг	35.4	37.2	1.8
<b>Бусад өглөг</b>	<b>14,286.0</b>	12,556.1	(1,729.9)
Байгууллагад төлөх өглөг	3,486.5	1,244.0	(2,242.5)
Хувь хүмүүст төлөх өглөг	29.7	125.3	95.6
Татварын өглөг /ОНӨААТҮГ/	2,950.7	3,160.9	210.2
НДШ-ийн өглөг /ОНӨААТҮГ/	2,701.4	2,968.5	267.1
Ноогдол ашгийн өглөг /ОНӨААТҮГ/	2.0	2.0	
Дансны өглөг /ОНӨААТҮГ/	5,115.7	5,055.4	(60.3)
<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>2,885.2</b>	19.0	(2,866.2)
<b>Урт хугацаат өр төлбөр дүн</b>	<b>1,355.3</b>	770.9	(584.4)
Арилжааны банк	144.0	109.6	(34.4)
Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	1,211.3	661.3	(550.0)
<b>Дүн</b>	<b>21,797.0</b>	22,383.6	586.6
<b>Үүнээс байгууллагын төрлөөр:</b>			
Төсөвт байгууллага	3,184.3	9,368.2	6,183.9
Төсөл, сан	2,806.7	161.2	(2,645.5)
Төрийн сан	9.5	93.3	83.8
ОНӨААТҮГ	15,796.5	2,760.9	(3,035.6)
<b>Дүн</b>	<b>21,797.0</b>	<b>22,383.6</b>	<b>586.6</b>

*Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нийт өглөгийн 35.3 хувь буюу 7,908.0 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн, 35.2 хувийг буюу 7,887.7 сая төгрөгийг “Сэлэнгэ-Энерго” ОНӨААТҮГ-ын, 7.7 хувь буюу 1,733.1 сая төгрөгийг “Гавшгай ус” ААТҮГ-ын, 8.8 хувь буюу 1,970.2 сая төгрөгийг “Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ-ын өглөг тус тус эзэлж байна.

Богино хугацаат өр төлбөрийн дүн өмнөх оноос 1,171.0 сая төгрөгөөр өсөхөд хөрөнгө бэлтгэхтэй холбоотой өглөг 5,470.3 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлын өглөг 260.2 сая төгрөгөөр, НДШ-ийн өглөг /ОНӨААТҮГ/ 267.1 сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийт өр төлбөрийн 57.0 хувь буюу 12,760.9 сая төгрөгийг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн, 41.9 хувь буюу 9,368.2 сая төгрөгийг төсөвт байгууллагын, 0.7 хувь буюу 161.2 сая төгрөгийг төсөл сангийн барьцаа хөрөнгийн, 0.4 хувь буюу 93.3 сая төгрөгийг төрийн сангийн өр төлбөр тус тус эзэлж байна.

Урьдчилж орсон орлого дансны эхний үлдэгдэл 2,885.2 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 19.0 сая төгрөг болж, 2,866.2 сая төгрөгөөр буурсан нь “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ нь 2,874.8 сая төгрөг, “Мандал энерго” ОНӨААТҮГ нь 1,571.9 сая төгрөгийг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэснээс шалтгаалсан байна.

Дансны өглөг дансны эхний үлдэгдэл 5,115.7 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 5,055.4 сая төгрөг болж, 60.3 сая төгрөгөөр буурсан нь “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын 88.5 сая төгрөгийн, “Сүхбаатар хөгжил тохижилт” ОНӨААТҮГ-ын 74.7 сая төгрөгийн өглөгийг барагдуулснаас голлон шалтгаалсан байна.

Урт хугацаат зээлийн өр төлбөр оны эцэст 584.4 сая төгрөгөөр буурсан нь “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын хөрөнгө оруулалтын гэрээгээр 2020 онд авсан 1,200.0 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтөд 550.0 сая төгрөгийг шилжүүлснээс голлон шалтгаалсан байна.

### Аудитын илрүүлэлт:

Төсвийг зохистой удирдаагүй ба төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 11 байгууллага **17.4** сая төгрөгийн төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна. /Хавсралт №1-д дэлгэрэнгүй харуулав./

### 3.5.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 281,816.8 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 342,272.3 сая төгрөг болж, 60,455.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 9 Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/
<b>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</b>	82,004.2	82,982.2	978.0
Өмч /төрийн/ /ОНӨААТҮГ/	2,600.3	6,938.3	4,338.0
Эздийн өмчийн бусад хэсэг /ОНӨААТҮГ/	6,579.1	10,414.4	3,835.3
Хуримтлагдсан үр дүн	62,983.3	110,042.9	47,059.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	126,970.8	129,029.8	2,059.0
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	679.1	2,864.7	2,185.6
<b>Дүн</b>	<b>281,816.8</b>	<b>342,272.3</b>	<b>60,455.5</b>
<b>Үүнээс байгууллагын төрлөөр:</b>			
Төсөвт байгууллага	201,088.1	227,118.5	26,030.4
Төсөл, сан	217.2	326.9	109.7
Төрийн сан	5,866.5	13,289.3	7,422.8
ОНӨААТҮГ	74,645.0	101,537.6	26,892.6
<b>Дүн</b>	<b>281,816.8</b>	<b>342,272.3</b>	<b>60,455.5</b>

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өмнөх оноос 60,455.5 сая төгрөгөөр өсөхөд дараах өөрчлөлтүүд голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- Тайлант онд үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 13,520.9 сая төгрөгөөр тайлагнагдсан,
- Сайхан сумын Сум дундын эмнэлэгт бүтцийн өөрчлөлт хийж, 757.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шинээр байгуулагдсан Сайхан сумын ЭМТ-д шилжүүлсэн, Мандал сумын Хот тохижилт, үйлчилгээний газарт бүтцийн өөрчлөлт хийж, 1,014.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шинээр байгуулагдсан “Тохилог Хараа” ААТҮГ-т шилжүүлсэн,
- “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын Төрийн албан хаагчийн 120 айлын орон сууцыг улсын комиссын актаар хүлээн авч 4,338.0 сая төгрөгийн барилгыг бүртгэсэн,

**Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

- Сайхан сумын Сум дундын эмнэлэгт бүтцийн өөрчлөлт хийж, шинээр үүсэн байгуулагдсан Сайхан сумын ЭМТ-д 1,672.3 сая төгрөгийн дахин үнэлгээтэй хөрөнгө шилжин ирснээс голлон шалтгаалж хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 2,058.9 сая төгрөгөөр өссөн гэх мэт.

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 6 ОНӨААТҮГ, 8 ТТЗ-ийн нийт 33 байгууллагын өмчийн өөрчлөлтийн тайланд нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой **2,864.7** сая төгрөгийн залруулга хийгдсэн байна. Үүнд:

Хүснэгт №10. Залруулга хийгдсэн байгууллагын судалгаа

/сая төгрөг/

№	Байгууллагын нэр	Дүн	№	Байгууллагын нэр	Дүн
1	“Цант Орхон” ААТҮГ	4.0	18	Түнхэл тосгоны Захирагчийн ажлын алба	11.6
2	“Туулын хишиг” ОНӨААТҮГ	(1.7)	19	Түнхэл тосгоны сургууль	1.1
3	“Тохилог Хараа” ААТҮГ	2,114.6	20	Цагааннуур сумын ЭМТ	(1.4)
4	“Сүхбаатар хөгжил Тохижилт” ОНӨААТҮГ	44.1	21	Цагааннуур сумын ЕБС	4.5
5	“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ	(6.8)	22	Цагааннуур сумын цэцэрлэг	0.3
6	Бугант тосгоны сургууль	0.4	23	Сайхан сумын ЭМТ	692.6
7	Мандал сумын Орон нутгийн ерөнхий орлого	(0.5)	24	Сайхан СХС	(34.8)
8	Мандал сумын Өрхийн эмнэлэг	(1.1)	25	Баруунбүрэн сумын ЕБС	(1.0)
9	Мандал сумын СХС	20.6	26	Дулаанхаан тосгоны соёлын төв	(0.5)
10	Мандал сумын Нархан цэцэрлэг	1.2	27	Сүхбаатар сумын 1-р цэцэрлэг	1.3
11	Түнхэл тосгоны соёлын төв	0.4	28	Сүхбаатар сумын 6-р сургууль	0.5
12	Мандал сумын ИТХ	0.5	29	Сүхбаатар сумын 4-р цэцэрлэг	0.1
13	Хэрх тосгоны ЕБС	(1.5)	30	Сүхбаатар сумын 2-р сургууль	2.1
14	Мандал сумын 2-р сургууль	3.1	31	Сүхбаатар сумын Хүүхдийн ясли	0.4
15	Мандал сумын 1-р сургууль	2.3	32	Сүхбаатар сумын 2-р цэцэрлэг	0.4
16	Мандал сумын 3-р сургууль	1.3	33	Түшиг сумын Соёлын төв	(0.4)
17	Мандал сумын ЗДТГ	7.0			
<b>Нийт дүн</b>					<b>2,864.7</b>

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой материаллаг хэмжээний залруулгыг тодруулбал:

- Мандал сумын Хот тохижилт, үйлчилгээний газарт бүтцийн өөрчлөлт хийж, шинээр байгуулагдсан “Тохилог Хараа” ААТҮГ-ын балансын эхний үлдэгдлийг оруулж, засгийн газрын оруулсан капиталыг 1,014.2 сая төгрөгөөр, дахин үнэлгээний нэмэгдлийг 1.5 сая төгрөгөөр, хуримтлагдсан үр дүнг 1,098.7 сая төгрөгөөр зэрэг нийт 2,114.6 сая төгрөгийн залруулга хийсэн,

- Сайхан сумын ЭМТ нь бүтцийн өөрчлөлтөөр суманд шилжиж ирсэнтэй холбоотойгоор балансын эхний үлдэгдлийг оруулж, засгийн газрын оруулсан капиталыг 757.3 сая төгрөгөөр, дахин үнэлгээний нэмэгдлийг 1,672.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, хуримтлагдсан үр дүнг 1,737.0 сая төгрөгөөр бууруулан нийт 692.6 сая төгрөгийн залруулга хийсэн,
- “Сүхбаатар хөгжил тохижилт” ОНӨААТҮГ нь үндсэн хөрөнгийн элэгдэл илүү байгуулсан 44.1 сая төгрөгийг залруулан, хуримтлагдсан үр дүнг нэмэгдүүлсэн,
- Мандал сумын СХС нь өмнөх онуудад дутуу тооцоолсон 20.6 сая төгрөгийн зээлийн хүүгийн алдангийг нөхөн тооцож, хуримтлагдсан үр дүнг нэмэгдүүлж залруулсан гэх мэт.

Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн тайланд нэгтгэгдсэн орон нутгийн өмчит 9 аж ахуйн нэгжүүд үйл ажиллагааны үр дүнгээр тус бүр 0.1-2,392.3 сая төгрөг, нийт дүнгээр 5,236.5 сая төгрөгийн алдагдал хүлээж өөрийгөө санхүүжүүлэн ажиллаж чадаагүй байна.

### 3.5.9 Орлогын данс

Тайлант онд орон нутгийн төсөвт байгууллагуудын өөрийн орлогыг 214.8 сая төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 331.2 сая төгрөг төвлөрч, төлөвлөгөөг 54.2 хувиар давуулан биелүүлсэн байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

Орлогын данстай холбоотой нийт **164.3** сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Эмийн болон Ковид-19 өвчнийг илрүүлэх оношлуурын тооцоог тухай бүр хийж баталгаажуулаагүйгээс Ерөө сумын ЭМТ 0.4 сая төгрөг, Зүүнбүрэн сумын ЭМТ 8.3 сая төгрөг, Сант сумын ЭМТ 3.5 сая төгрөг, Шаамар сумын ЭМТ 0.7 сая төгрөг, Түнхэл тосгоны ЭМТ 1.3 сая төгрөг зэрэг нийт **14.2** сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн,
- Сант сумын ТТЗ 1.2 сая төгрөг, Цант Орхон ОНӨААТҮГ 0.4 сая төгрөг, Туулын хишиг ОНӨААТҮГ 28.2 сая төгрөг зэрэг нийт **29.8** сая төгрөгийн түрээсийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй,
- “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ орон сууцны хуваарьт төлбөрийн **2.3** сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн,
- Сумын төсвийн орлогод төвлөрүүлэх бэлчээрийн төлбөрийн орлого **9.0** сая төгрөгийг Хушаат сум нь Мөнх толгойн хөгжил, Даагат хөгжил сангийн дансанд төвлөрүүлсэн, торгуулийн орлого **5.2** сая төгрөгийг Орхон сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар авч зарцуулсан,
- Бугант тосгоны Захирагчийн алба 54.0 сая төгрөг, Илдэн бүрэн ААТҮГ 49.8 сая төгрөг зэрэг нийт **103.8** сая төгрөгийн нийгмийн хариуцлагын хүрээнд ААНБ-аас өгсөн хандивыг ОНХС-ийн дансанд төвлөрүүлэлгүйгээр зарцуулсан.

### 3.5.10 Зардлын данс

Зардлын данстай холбоотой нийт **540.6** сая төгрөгийн зөрчил илэрлээ.

#### Аудитын илрүүлэлт:

1. Аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд дараах **158.2** төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

#### ЗДНХ:

- Онцгой байдлын газарт шилжүүлсэн **87.1** сая зардлын зарцуулалтын тайланг тухай бүр хүлээн авч, хянаагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй,
  - Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Хөдөлмөрийн тухай хуулиудын эмхэтгэл худалдан авах зардалд 1.0 сая төгрөг, “Сэлэнгэ аймгийн хууль зүйн алба-2” ном хэвлүүлэх зардалд 5.0 сая төгрөг, аймгийн стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын зөвлөх үйлчилгээний зардалд 9.0 сая төгрөг зэрэг нийт **15.0** сая төгрөгийг шилжүүлсэн боловч хүлээн авсан талаар холбогдох баримтгүй, бүртгэл, тайланд тусгаагүй байна.
  - Урьдчилан төлөвлөх боломжтой арга хэмжээнд **42.3** сая төгрөгийг зарцуулсан байна.
  - Аймгийн Цагдаагийн газрын “Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох” арга хэмжээний хоол хүнс, шатахууны **13.8** сая төгрөгийн зарцуулалтын тайланг гаргаагүй байна.
2. Аймгийн ТЭЗ-ийн харьяа байгууллагуудад нийт **382.4** сая төгрөгийн алдаа, зөрчил илэрлээ.
    1. Цалин, урамшуулал, тусламжтай холбоотой нийт **169.8** сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. /Хавсралт №2-т дэлгэрэнгүй харуулав./ Үүнд:
      - Цалин, нэмэгдэл, урамшил, тэтгэмжийг алдаатай тооцоолсон, тушаал шийдвэрэгүйгээр буюу давхардуулан олгосон, сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагчдын сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа болоогүй байхад үр дүнгийн урамшуулал олгосон зэргээр 51 байгууллага **90.1** сая төгрөгийн цалин, урамшуулал олгосон,
      - Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон албан хаагчид олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг зөрүүтэй тооцож, 12 байгууллага **79.7** сая төгрөг илүү олгосон,
    2. Ерөө сумын ЗДТГ 2.6 сая төгрөг, Мандал сумын ИТХ 2.8 сая төгрөг, аймгийн ИТХ 14.3 сая төгрөг, ГБХЗХГ 2.7 сая төгрөг зэрэг нийт **22.4** сая төгрөгийн батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.
    3. ААТҮГ-ууд худалдан авах ажиллагаатай холбоотой хууль, журмыг зөрчин Сүхбаатар хөгжил тохижилт 60.0 сая төгрөг, Сэлэнгэ-Энерго 41.8 сая төгрөг, Туулын хишиг 63.0 сая төгрөг зэрэг нийт **164.8** сая төгрөгийн худалдан авалт хийсэн,
    4. Алтанбулаг сумын ОНХС 0.5 сая төгрөг, Сант сумын ЗДТГ 0.4 сая төгрөг, Шаамар сумын ЗДТГ 24.5 сая төгрөг зэрэг нийт **25.4** сая төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг илүү олгосон байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт:

Аймаг, сумдын 2021 оны орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 26,548.6 сая төгрөг, татварын бус орлогыг 2,844.0 сая төгрөг, өөрийн орлогыг 30.0 сая төгрөг зэрэг нийт **29,422.6** сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр **38,506.1** сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 30.9 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт № 11 Аймаг, сумдын төсвийн орлого

/сая төгрөг/

Орлогын нэр төрөл	2021 он							
	Аймаг		Сумд		Нийт орлого			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Урсгал орлого	19,525.2	21,646.7	9,867.4	16,681.5	29,392.6	38,328.2	8,935.6	130.4
Татварын орлого	18,425.2	20,557.8	8,123.4	13,666.1	26,548.6	34,223.9	7,675.3	128.9
Хувь хүний орлогын албан татвар	15,700.0	16,243.9	2,257.7	2,931.7	17,957.7	19,175.6	1,217.9	106.8
ХХОАТ-ын буцаалт	(784.8)	(784.8)	-	-	(784.8)	(784.8)		100.0
Хөрөнгийн албан татвар	1,870.0	1,973.4	256.1	1,439.4	2,126.1	3,412.8	1,286.7	160.5
Бусад татвар, төлбөр, хураамж	1,640.0	3,125.3	5,609.6	9,295.0	7,249.6	12,420.3	5,170.7	171.3
Татварын бус орлого	1,100.0	1,088.9	1,744.0	3,015.4	2,844.0	4,104.3	1,260.3	144.3
Хөрөнгийн орлого	30.0	177.9	-	-	30.0	177.9	147.9	593.0
Нийт орлого	19,555.2	21,824.6	9,867.4	16,681.5	29,422.6	38,506.1	9,083.5	130.9

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЭЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө 2,269.4 сая төгрөгөөр, сумдын төсвийн орлогын төлөвлөгөө 6,814.1 сая төгрөгөөр, нийт төсвийн орлого 9,083.5 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

#### Давж биелсэн орлогууд:

- **Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого:** Алтанбулаг, Баянгол, Баруунбүрэн Ерөө, Мандал, Хүдэр, Цагааннуур, Түшиг, Шаамар, Хушаат зэрэг сумдад ойгоос бэлтгэх хэрэглээний болон түлээний мод бэлтгэх зөвшөөрөл нэмэгдсэнээр мод бэлтгэх эрхийн бичгийн орлого нийт 2,998.2 сая төгрөгөөр,
- **Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого:** Алтанбулаг, Баянгол, Ерөө, Мандал, Орхон, Орхонтуул, Сайхан, Цагааннуур, Хүдэр, Хушаат, Жавхлант, Түшиг,

Шаамар зэрэг сумдад ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах хадлангийн талбайн орлого төвлөрснөөс, бусад байгалийн баялаг ашигласны төлбөр нэмэгдсэнээс шалтгаалан орлого 3,523.9 сая төгрөгөөр,

- **Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого:** Самрын ургацын нөөц өндөр тогтоогдож, ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар самар түүх иргэн, ААНБ-уудын тоо өссөнөөс шалтгаалан 523.2 сая төгрөгөөр,
- **Газрын төлбөрийн орлого:** Өмнөх оны төлбөрийн үлдэгдлийг барагдуулснаас орлого 889.5 сая төгрөгөөр давж биелсэн байна.
- **Малын тоо толгойн албан татварын орлого:** Тус орлогыг 2021 оны төсвийн орлогын төлөвлөгөөнд Орхон, Цагааннуур, Сайхан зэрэг 3 сум төлөвлөсөн боловч бусад 8 сум нь төлөвлөөгүйгээс шалтгаалсан орлого 1,179.1 сая төгрөгөөр давж биелсэн үзүүлэлттэй байна.

#### **Төлөвлөгөө тасарсан орлогууд:**

- **Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого:** Төлөвлөлтийг орон нутгийн газрын байршил, ан амьтны нөөц, ИТХ-аар баталсан ан агнуурын зөвшөөрөл зэргийг харгалзан төлөвлөөгүйгээс шалтгаалан 9.4 сая төгрөгөөр тасарсан байна.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан “Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай” хуулиар Сэлэнгэ аймгийн 2021 оны төсвийн орон нутгийн суурь орлогыг 17,247.0 сая төгрөг, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 4,038.6 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг 10,042.5 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 656.4 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 53,097.7 сая төгрөг зэрэг нийт **85,082.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлж**, аймгийн төсвийн урсгал зардлыг 6,277.3 сая төгрөг, замын сангийн хөрөнгө оруулалтыг 553.5 сая төгрөг, сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 14,796.0 сая төгрөг, тусламж дэмжлэгийг 63,455.4 сая төгрөг зэрэг нийт **85,082.2 сая төгрөгийн төсвийг зарцуулахаар** баталсан байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн саналд аймгийн төсвийн нийт орлого болон зарлагыг 1,740.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 86,822.2 сая төгрөгөөр тооцож, төлөвлөсөн байна. Үүнд:

- Газрын дуудлага худалдааны орлогыг 40.0 сая төгрөг,
- ХХОАТ-ын орлогыг 1,200.0 сая төгрөг,
- Урьд оны мөнгөн хөрөнгийн зарцуулагдаагүй үлдэгдлээс 500.0 сая төгрөг зэрэг нийт 1,740.0 сая төгрөгийн орлого нэмэгдүүлэхээр,
- Аймгийн ИТХ-ын зардлыг 277.2 сая төгрөг,
- Аймгийн ЗДНХ-ийн зардлыг 1,090.7 сая төгрөг,
- Аймгийн Засаг даргын МХХ зардлыг 129.8 сая төгрөг зэрэг нийт 1,740.0 сая төгрөгийн зарлага нэмэгдүүлэхээр тооцсон байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 07 дугаар тогтоолоор хандив тусламжийн эх үүсвэрээр аймгийн ОНХС-д төвлөрүүлэх орлого болон

зарлагыг 1,510.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тооцож, аймгийн 2021 оны нийт орлого, зарлагыг **88,332.2** сая төгрөгөөр баталсан байна.

Улсын Их Хурлын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар “Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулан Сэлэнгэ аймгийн санхүүгийн дэмжлэгийг 1,187.5 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг 298.9 сая төгрөгөөр, ТЗШ-ийн байгууллагын санхүүжилтийг 1,529.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, баталсан бол дээрх хуулийг үндэслэн аймгийн ИТХ-ын 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 16 дугаар тогтоолоор дараах өөрчлөлтийг хийж, аймгийн 2021 оны төсвийн нийт орлого, зарлагыг **92,776.7** сая төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

**Орлого талд:**

- ХХОАТ-ын буцаан олголтын хэмнэлт 1,115.2 сая төгрөг,
- ОНХС-ийн эх үүсвэр /оны эхний үлдэгдэл 903,2 сая төгрөг, улсаас олгох санхүүгийн дэмжлэг 299,0 сая төгрөг/-ийг нийт 1,202.2 сая төгрөг,
- Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 1,187.5 сая төгрөг,
- Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 1,529.7 сая төгрөг,
- Урьд оны мөнгөн хөрөнгийг үлдэгдлээс 500.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэхээр,
- ОНХС-д төвлөрөх хандив тусламжийн орлогыг 590.0 сая төгрөгөөр бууруулахаар тооцож, нийт дүнгээр орлогыг 4,444.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

**Зарлага талд:**

- Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлыг 354.6 сая төгрөгөөр;
- Аймгийн ЗДТГ-ын урсгал зардлыг 306.8 сая төгрөгөөр,
- Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн зардлыг 770.0 сая төгрөгөөр,
- БТСГ-ын урсгал зардлыг 374.0 сая төгрөгөөр,
- Аймгийн ОНХО-ын зардлыг 392.0 сая төгрөгөөр,
- Аймгийн Соёлын хэлтсийн урсгал зардлыг 32.5 сая төгрөгөөр,
- ОНХС-ийн хөрөнгийн зардлыг 1,202.2 төгрөгөөр,
- Сумдад олгох санхүүгийн дэмжлэгийн 72.5 сая төгрөгөөр,
- ЕБС-ийн урсгал зардлыг 2579.7 сая төгрөгөөр зэрэг нийт 6,084.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэхээр,
- СӨБ-ын байгууллагын урсгал зардлыг 1,032.1 сая төгрөгөөр,
- Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын урсгал зардлыг 17.6 сая төгрөгөөр,
- ОНХС-д төвлөрөх хандив тусламжийн орлогоор хийгдэх хөрөнгө оруулалтын зардлыг 590.0 сая төгрөгөөр гэх мэт нийт 1,639.7 сая төгрөгөөр бууруулсан байна.

Сумдын 2021 оны төсвийн нийт орлогыг 9,867.4 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 168.0 сая төгрөг, ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс 859.5 сая төгрөг, ОНХС-ийн хандиваар 510.0 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс 4,789.0 сая төгрөг, СХС-ийн эх үүсвэрийг 2,531.1 сая төгрөг, нийт орлого, зарлагыг 18,725.0 сая төгрөгөөр эцэслэн баталсан байна.

Ингэснээр Сэлэнгэ аймгийн нийт орлого, зарлагыг **111,501.7** сая төгрөгөөр эцэслэн баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 27 хөтөлбөрт зориулан **111,501.7 сая төгрөгийн** төсөв батлагдсанаас 90,488.8 сая төгрөгийг урсгал зардалд, 18,538.6 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, СХС-ийн зээлд 2,474.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Нийт зардлын 54,627.4 сая төгрөгийг ТЗШ-ээс, 39,937.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 10,341.5 сая төгрөгийг ОНХС-аас, 656.4 сая төгрөгийг ЭМДС-аас, 168.0 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас, 1,984.8 сая төгрөгийг СХС-ийн үлдэгдлээс, 2,356.0 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 1,430.0 сая төгрөгийг нийгмийн хариуцлагын хүрээнд ААНБ-аас өгсөн хандивын орлогоос тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр ТЗШ-ээс 53,196.7 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 36,265.9 сая төгрөг, ОНХС-аас 10,341.5 сая төгрөг, ЭМДС-аас 400.4 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 280.8 сая төгрөг, 1,995.0 сая төгрөгийг СХС-ийн үлдэгдлээс, нийгмийн хариуцлагын хүрээнд ААНБ-аас өгсөн хандивын орлогоос 180.0 сая төгрөг зэрэг нийт **102,660.3** сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 100,673.9 сая төгрөг буюу 90.3 хувьтай тайлагнагдсан нь ЭМДС-ийн санхүүжилтийг гүйцэтгэлээр нь олгосон, ТЗШ болон орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийн хэмнэгдсэн зардлыг татан төвлөрүүлсэн зэргээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн НДШ-ийн зардал нийт 1,538.9 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 807.2 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 34.4 сая төгрөгөөр, нормативт зардал 540.1 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 80.4 сая төгрөгөөр, томилолтын зардал 55.2 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 141.3 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 868.9 сая төгрөгөөр, урсгал шилжүүлэг 186.9 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд ОНХО, ОНХС, Замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээнд 18,538.6 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 12,754.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар *IKовид 19 цар тахалтай холбогдуулан аж ахуйн нэгж, иргэдээс өгсөн* 382.5 сая төгрөг, аймгийн ЗДНХ-ийн зардлаас 188.2 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 3,570.4 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,048.9 сая төгрөг, ЭМДС-аас 3,853.5 сая төгрөг зэрэг нийт 10,043.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардалд 1,099.7 сая төгрөг, НДШ-д 135.8 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 34.0 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 348.2 сая төгрөг, нормативт зардалд 2,850.6 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 411.7 сая төгрөг, томилолт, зочны зардалд 4.9 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 573.2 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 1,980.5 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 1,487.7 сая төгрөг, хөрөнгийн зардалд 1,083.8 сая төгрөг зэрэг нийт 10,010.1 сая төгрөгийг зарцуулж, сумдын ЭМТ-ийн зарцуулагдаагүй 33.4 сая төгрөгийн үлдэгдэл тайлагнагдсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

1. Төрийн албан хаагчийн төрийн алба хаасан хугацаа, дундаж цалинг холбогдох журмын дагуу тогтоогоогүй, тооцоолол, төлөвлөлтийг ТЕЗ-ийн зүгээс хянаж, баталгаажуулаагүйгээс төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламжийг илүү тооцож, олгосон зөрчил тодорхой хэмжээгээр илэрсэн байна.

Цаашид өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг төсвийн шууд захирагчдын зүгээс тооцож, тогтоосон тооцооллыг аймгийн ТЕЗ-ийн зүгээс хянаж, баталгаажуулан төсөвт тусган, төлөвлөж байх нь зүйтэй юм.

2. Аймгийн ЭМГ-ын даргын 2020 оны А/76 дугаар тушаалаар батлагдсан сум, тосгоны ЭМТ-ийн орны тоог эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн батлагдсан төсөвтэй харьцуулж үзэхэд 1 оронд дунджаар 1.2-2.7 сая төгрөг буюу ялгавартай тооцож, төлөвлөсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 12 Сум, тосгоны ЭМТ-ийн эмийн зардлыг орны тоотой харьцуулсан судалгаа.

/сая төгрөг/

№	Сум, тосгоны эрүүл мэндийн төв	2021 оны төсөв	Зохицуулалт	Зөрүү	Батлагдсан орны тоо	1 оронд ногдох зардал
1	Алтанбулаг	33.47	32.28	(1.19)	13.00	2.48
2	Баруунбүрэн	27.26	38.05	10.79	14.00	2.72
3	Баянгол	28.61	28.61	-	15.00	1.91
4	Ерөө	18.54	18.54	-	15.00	1.24
5	Бугант	18.52	18.52	-	14.00	1.32
6	Жавхлант	16.60	16.60	-	11.00	1.51
7	Зүүнбүрэн	19.00	19.00	-	13.00	1.46
8	Орхон	21.80	22.33	0.52	12.00	1.86
9	Орхонтуул	13.00	18.98	5.98	10.00	1.90
10	Рашаант	19.20	19.20	-	10.00	1.92
11	Сайхан	106.00	106.00	-	60.00	1.77
12	Номгон	15.73	15.73	-	10.00	1.57
13	Сант	25.88	32.79	6.91	12.00	2.73
14	Түшиг	11.60	11.60	-	10.00	1.16
15	Хушаат	21.29	21.29	-	12.00	1.77
16	Хүдэр	28.65	31.36	2.71	13.00	2.41
17	Цагааннуур	28.82	35.99	7.17	20.00	1.80
18	Шаамар	15.11	15.11	-	12.00	1.26
19	Дулаанхаан	18.59	19.37	0.78	10.00	1.94
20	Түнхэл	21.72	23.52	1.80	16.00	1.47
21	Хэрх	25.20	25.20	-	15.00	1.68
	<b>Дүн</b>	<b>534.58</b>	<b>570.06</b>	<b>35.48</b>	<b>317.00</b>	

Цаашид тооцоо судалгаанд үндэслэн эмийн зардлыг бодитой төлөвлөж байх шаардлагатай байна.

3. ЗДНХ-ийн зардлаас хүчин төгөлдөр бус /Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдаж, 2018 оны 318 дугаар тушаалаар хүчингүй болсон/ "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын холбогдох заалтуудыг үндэслэн 439.4 сая төгрөг, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын холбогдох заалтыг үндэслэн 2021 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн А/68 дугаар захирамжаар 5.2 сая төгрөг зэрэг нийт 444.6 сая төгрөгийг зарцуулах шийдвэр гаргасан байна.

Цаашид хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг үндэслэн захирамж, шийдвэрээ гаргаж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулах нь зүйтэй юм.

4. ТЗШ-ийн хувьсах зардлын санхүүжилт авсан төрийн бус өмчийн 2 цэцэрлэгийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн хавсралт "Сургалт эрхлэх нөхцөл шаардлага"-д үндэслэлгүйгээр гүйцэтгэлээр санхүүжилтийг олгосон байна. Үүнд:

- Мандал сумын Эден цэцэрлэгийн барилгын хүчин чадал 25, бүлгийн тоо 1 гэж заасан байхад 77 хүүхдийн санхүүжилт олгосон,
- Баянгол сумын Бүжинхэн цэцэрлэгийн барилгын хүчин чадал 50, бүлгийн тоо 2 гэж заасан байхад 103 хүүхдийн санхүүжилтийг тус тус олгосон байна.

Цаашид сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн хавсралт “Сургалт эрхлэх нөхцөл шаардлага”-д дурдсан үзүүлэлтүүдийг одоо ажиллаж байгаа нөхцөл байдалд тулгуурлан, шинэчлэн батлах шаардлагатай байна.

5. ЗДНХ-ийн зардлаас иргэдийн тавьсан хүсэлтийн дагуу тусламж дэмжлэг олгохдоо харилцан адилгүй буюу 0.3-3.0 сая төгрөгөөр тооцсон байна.

Иймд нөхцөл байдлыг харгалзан, ямар тохиолдолд хэдэн төгрөгийн тусламж, тэтгэмж олгохыг тогтоох нь зүйтэй юм.

### 3.8 Аудитын гол асуудал

1. Сангийн сайдын 2015 оны 07 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан “Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”-д тусгасан “ИТХ-д суудалтай намуудад олгох дэмжлэг” гэсэн ангиллыг үндэслэн аймгийн ИТХ-д суудал бүхий намын санхүүжилтэд 180.0 сая төгрөг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

2. Аймгийн Засаг дарга Ш.Оргил, Сэлэнгэ-Энерго ОНӨААТҮГ-ын дарга Э.Эрдэнэбаатар нарын 2021 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр баталсан “Хүйтний улирлын нүүрсний нөөц бий болгоход зориулсан санхүүгийн урьдчилгаа олгох гэрээ”-г нэг талаас аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга О.Мөнхбаяр, нөгөө талаас Сэлэнгэ-Энерго ОНӨААТҮГ-ын ерөнхий нягтлан бодогч Д.Ванчигмаа нар төлөөлж, Захиргааны хуулийн холбогдох заалтуудыг үндэслэн байгуулсан байна.

2021 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр Орон нутгийн ерөнхий орлогын данснаас 280.0 сая төгрөгийг Сэлэнгэ-Энерго ОНӨААТҮГ-ын Төрийн банк дахь 240400676007 тоот дансанд шилжүүлж, 2021 оны 10-12 дугаар сард төсөвт байгууллагуудын халаалтын зардлаас суутган тооцсон байна.

3. Ковид-19 цар тахлын тархалт эрчимжсэн, барилгын материалын үнийн өсөлт, хил гааль тодорхойгүй хугацаагаар хаасантай холбогдуулан аймгийн ОНХС, ОНХО-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалт, гүйцэтгэлийн ажил удааширсан тул аймгийн Засаг даргын 2021 оны “Орон нутгийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” А/414 дүгээр захирамжаар 2021 онд санхүүжүүлэхээр батлагдаж, гэрээ нь байгуулагдсан төсөл, арга хэмжээний олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн байна. Үүний дагуу ОНХО-аар хэрэгжүүлэх 4 төсөл, арга хэмжээний 178.7 сая төгрөг, замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 3 төсөл, арга хэмжээний 104.0 сая төгрөг, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 13 төсөл, арга хэмжээний 848.8 сая төгрөг зэрэг нийт 1,131.5 сая төгрөгийн санхүүжилтийг төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд аймгийн ТЕЗ-ийн мэдээлбэл зохих 153 мэдээллээс 108 мэдээллийг хугацаанд нь, 10 төрлийн 45 мэдээллийг хугацаа хоцроож шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

1. Аймгийн ТЕЗ-ийн тайлант оны үйл ажиллагаанд 111,501.7 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 100,674.0 сая төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 9.7 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “... батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

2. ЗДНХ-ийн зардлаас 25.3 сая төгрөгийн календарь, ном сэтгүүл хэвлүүлэх, сургалт хэлэлцүүлэг зохион байгуулах зардал гаргасан байна. Үүнд:

- 2021 оны цаг тооны бичиг хэвлүүлэх зардалд 9.6 сая төгрөг,
- “Хөгжил зүтгэл” сэтгүүл хэвлүүлэх зардалд 1.0 сая төгрөг,
- “Соёл урлагийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх нь” сургалт хэлэлцүүлэг, “Жишиг соёлын төв” улсын уралдаанд нэр дэвшүүлэх шалгаруулалт зохион байгуулах зардалд 2.2 сая төгрөг,
- Сэлэнгэ аймгийн шүүх байгуулагдсаны ойд зориулан “Үнэнийг дэнсэлсэн он жилүүд” ном хэвлүүлэх зардалд 4.0 сая төгрөг,
- “Сэлэнгийн шаргал намрууд” ном хэвлүүлэх зардалд 2.0 сая төгрөг,
- Худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын шилдэг ололт, амжилт, туршлагын талаар сэтгүүл хэвлүүлэх зардалд 6.5 сая төгрөг гэх мэт.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3-д “... бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” 1.5-д “... сургалт,

семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх” гэж заасныг зөрчсөн байна.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид 60.4 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 2,967.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 4 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах санал, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгөгдсөн байна.

Хүснэгт № 13 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	1	60.4	1	60.4	100.0
Албан шаардлага	10	2,967.4	7	2,734.2	50.0
Зөвлөмж	2	-	2	-	100.0
<b>Нийт дүн</b>	<b>13</b>	<b>3,027.8</b>	<b>10</b>	<b>2,794.6</b>	<b>80.0</b>

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2020, 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, холбогдох баримтууд

Өмнөх аудитаар өгсөн аймгийн ИТХ-д суудалтай намуудад санхүүжилт олгохоор батлуулж, хэрэгжүүлсэн, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан, шилэн дансны мэдээллийг тогтоосон хугацаанд нь бүрэн мэдээлээгүй болон урьдчилан төлөвлөх боломжтой зардлыг ЗДНХ-ийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн зөрчлийг арилгах албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан байна.

Тус аймгийн Засаг дарга буюу төсвийн ерөнхийлөн захирагчаар ажиллаж байсан Ш.Оргил нь МУ-ын Ерөнхий сайдын 2021 оны 11 сарын 04-ний өдрийн 172 дугаар захирамжаар үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн байна.

ЗДНХ-өөс анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан болон шилэн дансны мэдээллийг тогтоосон хугацаанд нь мэдээлж байх албан шаардлагыг хэрэгжүүлээгүй албан тушаалтнуудад сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Төрийн бус өмчийн сургуулийн өмнөх боловсрол, ЕБС-ийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын санхүүжилтийг **сар бүр хүүхэд өдрөөр хянаж**, сар болон улирал тутамд олгосон талаарх баримтыг архивын нэгж үүсгэн хадгалаагүйгээс тулган баталгаажуулах боломжгүй байсан учир дараагийн аудитаар уг асуудлыг нарийвчлан авч үзэх шаардлагатай.

#### 4. Аудитын илрүүлэлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 17 сумын төвлөрүүлэн захирагч, 224 төсвийн байгууллага, 23 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж зэрэг нийт 264 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Аудитад хамрагдсан 264 байгууллагаас 142 байгууллагыг түүвэрт хамруулж, 122 байгууллагад бие даасан дүгнэлт хүргүүлээ. Үүнд:

- 105 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”,
- 14 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”,
- 2 байгууллагын санхүүгийн тайланд “Сөрөг”,
- 1 байгууллагын санхүүгийн тайланд “Татгалзсан” дүгнэлт өгсөн болно.

Хүснэгт №14. Хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн байгууллагууд:

№	Байгууллагын нэрс	№	Байгууллагын нэрс
1	Ерөө сумын ТТЗ	8	Санхүүгийн хяналт, аудитын алба
2	Зүүнбүрэн сумын ТТЗ	9	Сүхбаатар хөгжил тохижилт ААТҮГ
3	Сайхан сумын ТТЗ	10	Сэлэнгэ орон сууц ОНӨААТҮГ
4	Сүхбаатар сумын ТТЗ	11	Туулын хишиг ОНӨААТҮГ
5	Хүдэр сумын ТТЗ	12	Тохилог хараа ААТҮГ
6	Шаамар сумын ТТЗ	13	Илдэнбүрэн ААТҮГ
7	Аймгийн ИТХ	14	Энх мэнд сувилал ААТҮГ

Эх сурвалж: Сэлэнгэ аймаг дахь ТАГ-ын Санхүүгийн тайлангийн аудитын нэгтгэл

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас “Сэлэнгэ үржлийн цөм сүргийн аж ахуй”, “Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт өгсөн бөгөөд “Тариалан эрхлэлтийг дэмжих дундын үйлчилгээний техникийн төв” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзлаа.

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 269.2 сая төгрөгийн 9 алдаа, зөрчил илрүүлснээс 151.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага, 4 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах санал, 118.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмжийг хүргүүлсэн.

#### 4.1 Албан шаардлага

1. ЗДНХ-ийн батлагдсан төсвөөс аймгийн Онцгой байдлын газарт шилжүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайланг тухай бүр хүлээн авч, хянаагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс шатахуун болон хамгаалах хэрэгслийн 87.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Энэ нь нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 6.1 дэх "Нөөц

хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээг хариуцан гүйцэтгэж байгаа байгууллага, ажилтан хөрөнгийн зарцуулалтын тайланг уг арга хэмжээг хэрэгжүүлж дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор гаргаж, тухайн шатны Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4317143938  
MICA0065 8055436

Шийдвэрлэсэн нь: Шатахуун, хамгаалах хэрэгслийн үлдэгдлийг 2022 оны хэрэглээнд суутган тооцох, тухай бүр тооцоог хянаж байх албан шаардлага хүргүүлэх.

2. ЗДНХ-ийн төсвөөс Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Хөдөлмөрийн тухай хуулиудын эмхэтгэл худалдан авахад 1.0 сая төгрөг, “Сэлэнгэ аймгийн хууль зүйн алба-2” ном хэвлүүлэхэд 5.0 сая төгрөг, аймгийн стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын зөвлөх үйлчилгээнд 9.0 сая төгрөг зэрэг нийт **15.0** сая төгрөгийг шилжүүлсэн боловч ном, төлөвлөгөөг хүлээн аваагүй, авлагаар тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага; 14.4.5. бүх орлого” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, үүссэн авлага, өр төлбөрийг бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэх.

3. ЗДНХ-ийн зардлаас тайлант онд урьдчилан төлөвлөх боломжтой дараах арга хэмжээнд зориулан **42.3** сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:

- Хүдэр сумын Эрэн хайх, аврах салбарын байрны дулаалгын засвар үйлчилгээний зардалд 24.5 сая төгрөг,
- Мандал сумын Дуу бүжгийн чуулгын урлагийн хувцас худалдан авахад 4.8 сая төгрөг,
- Ардын дуу бүжгийн Сэлэнгийн Долгио чуулгын урлагийн хувцас худалдан авахад 11.0 сая төгрөг,
- Жил бүр уламжлал болгон тэмдэглэдэг “Татвар төлөгчдийн өдрүүд”-ийг тэмдэглэх зардалд 2.0 сая төгрөг,

Дээрх зөрчил нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1 дэх “ Нөөц хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулна”, 2.1.5: “.... урьдчилан төлөвлөж, төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Урьдчилан төлөвлөх боломжтой арга хэмжээг ЗДНХ-ийн зардлаас санхүүжүүлэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

4. Сэлэнгэ аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 632, 2021 оны 155 дугаар шийдвэрээр Шаамар сумын ИТХ-ын даргаар ажиллаж байсан /хууль бусаар ажлаас халагдсан нь тогтоогдсон/ С.Мягмартогтохт ажилгүй байсан хугацааны цалин болох 6,7 сая төгрөгийг тус байгууллагын төсвөөс барагдуулсан боловч буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй байна.

Энэ нь Иргэний тухай хуулийн 498 дугаар зүйлийн 498.5 дахь “Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй.” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2 дахь “... гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна” гэсэн заалтыг хэрэгжүүлж, хохирлыг нөхөн төлүүлэн, төсвийг хохиролгүй болгох албан шаардлага хүргүүлэх.

5. Нийт 4 албан тушаалтан өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс алдаа зөрчлийг давтан гаргасан болон албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлж, албан үүргээ хангалтгүй гүйцэтгэн, материаллаг хэмжээний зөрчил гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэх.

#### **4.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Төсөв захиран зарцуулахтай холбоотой асуудал**

1.1 Илрүүлэлт: Орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн ерөнхий орлого, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, барьцаа, техник хяналт, эрх шилжсэн хөрөнгө оруулалтын дансны зарлагын гүйлгээнд аймгийн Засаг дарга бус ЗДТГ-ын СТСХ-ийн дарга 1 дүгээр гарын үсэг зурж, захиран зарцуулж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх “Дараах албан тушаалтан төсвийн ерөнхийлөн захирагч байна: 14.1.17: “аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн энэ хуулийн 14.1.15, 14.1.16-д зааснаас бусад төсвийн” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Зөвлөмж: Дээрх дансны зарлагын гүйлгээнд аймгийн Засаг дарга буюу ТЕЗ 1 дүгээр гарын үсэг зурж, захиран зарцуулж байх.

## **2. Анхан шатны баримттай холбоотой асуудал**

2.1.1 Илрүүлэлт: Тайлант онд ЗДНХ-ийн төсвөөс худалдан авсан 104.3 сая төгрөгийн бараа материал нь холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана...”, гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.1.2 Өгсөн зөвлөмж: Төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх.

2.2.1 Илрүүлэлт: ЗДНХ-өөс аймгийн Цагдаагийн газрын “Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох” арга хэмжээнд зарцуулсан 13.8 сая төгрөгийн хоол хүнс, шатахууны зарцуулалтын тайланг гаргаж, аймгийн ЗДТГ-т ирүүлээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 6.1 дэх “Нөөц хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээг хариуцан гүйцэтгэж байгаа байгууллага, ажилтан хөрөнгийн зарцуулалтын тайланг уг арга хэмжээг хэрэгжүүлж дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор гаргаж, тухайн шатны Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ” гэж заасныг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2.2 Өгсөн зөвлөмж: Арга хэмжээг хэрэгжиж дууссан тухай бүр зарцуулалтын тайланг хүлээн авч, гүйцэтгэлийг тооцож байх.

## **3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

3.1 Илрүүлэлт: Сумдын ЗДТГ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга нарт холбогдох албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлгийг хянах үүрэг бүхий ЭБАТ-ын нэмэгдлийг харилцан адилгүй хувь, хэмжээгээр тооцон олгож байна.

3.2 Зөвлөмж: УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 1-д хавсралтаар батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 3.1-д “Нийтийн албаны удирдлага нь ... албан тушаалынх нь цалингийн 40 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл урамшуулал олгох ...” гэж заасныг үндэслэн албан тушаалтнуудын дээрх чиг үүргийн дагуу хийгдэж буй ажлын ачаалал, цар хүрээг харгалзан нэмэгдлийг нэгдсэн журмаар тогтоож, шийдвэрлэх, биелэлтэд хяналт тавих.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Алдаа зөрчлийн утга	Үүнээс												
		Нийт алдаа, зөрчлийн		Залруулга		Төлбөрийн акт		Хариуцлага тооцуулах		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
<b>Санхүүгийн тайлангийн аудитын асуудал</b>														
1	ЗДНХ-өөс Онцгой байдлын газарт шилжүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайланг тухай бүр хүлээн авч, хянаагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан.	1	87.1								1	87.1		
2	ЗДНХ-ийн зардлаас ном хэвлүүлэх болон аймгийн стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын зөвлөх үйлчилгээний зардлыг санхүүжүүлсэн боловч ном, төлөвлөгөөг хүлээн аваагүй, авлагаар тусгаагүй.	1	15.0								1	15.0		
3	ЗДНХ-ийн зардлаас урьдчилан төлөвлөх боломжтой арга хэмжээг санхүүжүүлсэн.	1	42.3								1	42.3		
4	Шаамар сумын ИТХ-ын даргаар ажиллаж байсан /хууль бусаар ажлаас халагдсан нь тогтоогдсон/ С.Мягмартогтохт ажилгүй байсан хугацааны цалинг байгууллагын төсвөөс барагдуулсан боловч буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй.	1	6.7								1	6.7		
5	Нийт 4 албан тушаалтан нь өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс алдаа зөрчлийг давтан гаргасан болон албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлж, албан үүргээ хангалтгүй гүйцэтгэн, материаллаг хэмжээний зөрчил гаргасан байна.	1	-						1	-				

Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн тайланг нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

6	ЗДНХ-өөс санхүүжүүлсэн аймгийн Цагдаагийн газрын "Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох" арга хэмжээний хоол хүнс, шатахууны зарцуулалтын тайланг гаргаагүй.	1	13.8									1	13.8		
7	Орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн ерөнхий орлого, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, барьцаа, техник хяналт, эрх шилжсэн хөрөнгө оруулалтын дансны зарлагын гүйлгээнд аймгийн Засаг дарга бус ЗДТГ-ын СТСХ-ийн дарга 1 дүгээр гарын үсэг зурж, захиран зарцуулсан	1	-									1	-		
8	Бараа материалын худалдан авалтыг цахим баримтаар баталгаажуулаагүй.	1	104.3									1	104.3		
9	Сумдын ЗДТГ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга нарт холбогдох албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлгийг хянах үүрэг бүхий ЭБАТ-ын нэмэгдлийг харилцан адилгүй хувь, хэмжээгээр тооцон олгож байна.	1	-									1	-		
<b>Дүн</b>		<b>9</b>	<b>269.2</b>									<b>4</b>	<b>151.1</b>	<b>4</b>	<b>118.1</b>
<b>Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b>															
1	Аймгийн ТЕЗ-ийн мэдээлбэл зохих 153 мэдээллээс 10 төрлийн 45 мэдээллийг хугацаа хоцроож шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байна.	1	-									1	-		
2	ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолыг бүрэн хэрэгжүүлээгүй	1	-									1	-		
<b>Дүн</b>		<b>2</b>	<b>-</b>									<b>2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>		<b>11</b>	<b>269.2</b>									<b>6</b>	<b>151.1</b>	<b>4</b>	<b>118.1</b>

## Авлага, өр төлбөрийн данстай холбоотой алдаа, зөрчлийн нэгтгэл

4317143968

МОНА00968 9655436

/сая төгрөг/

д/д	Харьяалал	Байгууллагын нэр	Зөрчлийн утга		Нийт зөрчлийн дүн
			Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйгээс авлага үүсгэсэн	Төсвийг зохистой удирдаагүйгээс өр төлбөр үүсгэсэн	
1	Алтанбулаг	Сумын ЭМТ	-	1.36	1.36
2	Баруунбүрэн	Сумын ЭМТ	1.09	-	1.09
3	Ерөө	Сумын ЗДТГ	3.09	1.13	4.23
4	Зүүнбүрэн	Сумын ЭМТ	-	5.70	5.70
5	Мандал	Түнхэл ЭМТ	-	2.39	2.39
6	Мандал	Хэрх ЭМТ	0.14	-	0.14
7	Орхон	Сумын ЭМТ	1.79	-	1.79
8	Сайхан	Сайхан соёлын ордон	2.31	1.61	3.92
9	Сайхан	Номгон ЭМТ	0.71	-	0.71
10	Сант	Сумын ЭМТ	0.89	-	0.89
11	Сүхбаатар	Сумын ИТХурал	0.31	-	0.31
12	Сүхбаатар	Сумын ЗДТГ	0.21	-	0.21
13	Сүхбаатар	Бэлчир бүсийн сум дундын ойн анги	0.04	-	0.04
14	Сүхбаатар	Эмнэх баг өрхийн эмнэлэг	0.69	-	0.69
15	Түшиг	Сумын ИТХурал	0.11	-	0.11
16	Түшиг	Сумын ЗДТГ	0.40	-	0.40
17	Хушаат	Сумын ЭМТ	1.48	-	1.48
18	Хүдэр	Сумын ЗДТГ	19.12	-	19.12
19	Шаамар	Сумын ЗДТГ	0.85	-	0.85
20	Алтанбулаг	ЕБС	-	0.45	0.45
21	Ерөө	ЕБС	2.65	-	2.65
22	Ерөө	1 дүгээр цэцэрлэг	1.13	-	1.13
23	Мандал	ЕБС-3	-	0.20	0.20
24	Орхонтуул	Хүүхдийн цэцэрлэг	0.88	-	0.88
25	Орхонтуул	ЕБС-1	0.80	-	0.80
26	Орхонтуул	ЕБС-2	0.62	-	0.62
27	Сайхан	Сайхан сумын 1-р цэцэрлэг	0.18	-	0.18
28	Сайхан	Сайхан сумын 2-р цэцэрлэг	0.39	-	0.39
29	Сайхан	Сайхан сумын ЭМТ	1.93	-	1.93
30	Сүхбаатар	Хүүхдийн 1-р цэцэрлэг	-	1.18	1.18
31	Сүхбаатар	ЕБС-4	-	1.28	1.28
32	Сүхбаатар	Спорт сургууль	1.28	-	1.28
33	Хушаат	ЕБС	1.83	-	1.83
34	Сэлэнгэ шууд	Аймгийн ИТХ	-	1.61	1.61
35	Сэлэнгэ шууд	Аймгийн ЗДТГ	1.21	-	1.21
36	Сэлэнгэ шууд	Санхүүгийн хяналт, аудитын алба	0.12	-	0.12
37	Сэлэнгэ шууд	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар	-	0.45	0.45
<b>Нийт дүн</b>			<b>46.25</b>	<b>17.36</b>	<b>63.61</b>

## Цалин, урамшуулал, тусламжтай холбоотой алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

д/д	Харьяалал	Байгууллагын нэр	Зөрчлийн утга		Нийт зөрчлийн дүн
			Цалин, нэмэгдэл, урамшил, тэтгэмжийг алдаатай тооцоолсон, тушаал шийдвэргүйгээр буюу давхардуулан олгосон, сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагчдын сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа болоогүй байхад үр дүнгийн урамшуулал олгосон.	Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон албан хаагчид олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг тухайн албан тушаалын үндсэн цалингийн 3 жилийн дунджаар бодож олгоогүй.	
1	Алтанбулаг	Сумын ЗДТГ	1.02	-	1.02
2	Зүүнбүрэн	Сумын ЗДТГ	-	1.70	1.70
3	Зүүнбүрэн	Соёлын төв	-	1.68	1.68
4	Зүүнбүрэн	Сумын ЭМТ	0.84	-	0.84
5	Мандал	Сумын ЗДТГ	-	1.91	1.91
6	Мандал	Түнхэл ЭМТ	0.34	-	0.34
7	Орхон	Сумын ЗДТГ	0.21	-	0.21
8	Орхон	Соёлын төв	2.65	-	2.65
9	Орхонтуул	Сумын ЗДТГ	-	3.78	3.78
10	Орхонтуул	Рашаант ЭМТ	2.35	-	2.35
11	Сайхан	Соёлын төв номгон	-	0.86	0.86
12	Сайхан	Номгон ЭМТ	3.38	-	3.38
13	Түшиг	Соёлын төв	0.13	-	0.13
14	Түшиг	Сумын ЭМТ	0.23	-	0.23
15	Хүдэр	Соёлын төв	-	0.93	0.93
16	Цагааннуур	Соёлын төв	-	1.38	1.38
17	Шаамар	Сумын ИТХурал	-	2.66	2.66
18	Шаамар	Сумын ЗДТГ	0.63	1.37	2.00
19	Шаамар	Дулаанхан захирагчийн алба	-	0.49	0.49
20	Шаамар	Дулаанхаан соёлын төв	0.20	-	0.20
21	Алтанбулаг	1 дүгээр цэцэрлэг	0.41	-	0.41
22	Алтанбулаг	2 дугаар цэцэрлэг	1.45	-	1.45
23	Алтанбулаг	3 дугаар цэцэрлэг	0.51	-	0.51
24	Алтанбулаг	ЕБС	0.89	-	0.89
25	Ерөө	ЕБС	1.23	-	1.23
26	Ерөө	Бугант тосгон ЕБС	0.33	-	0.33
27	Ерөө	1 дүгээр цэцэрлэг	0.70	-	0.70
28	Ерөө	Бугант тосгон цэцэрлэг	0.10	-	0.10
29	Жавхлант	1 дүгээр цэцэрлэг	0.40	-	0.40
30	Зүүнбүрэн	1 дүгээр цэцэрлэг	0.18	-	0.18
31	Зүүнбүрэн	ЕБС	0.38	-	0.38
32	Мандал	Дуу бүжгийн чуулга	-	3.60	3.60
33	Орхонтуул	Хүүхдийн цэцэрлэг	0.96	-	0.96
34	Орхонтуул	ЕБС-1	0.96	-	0.96
35	Орхонтуул	ЕБС-2	0.96	-	0.96
36	Сайхан	Сайхан сумын ЭМТ	3.21	-	3.21
37	Сүхбаатар	Хүүхдийн 1-р цэцэрлэг	1.15	-	1.15
38	Сүхбаатар	Хүүхдийн 3-р цэцэрлэг	0.42	-	0.42
39	Сүхбаатар	Хүүхдийн 4-р цэцэрлэг	0.18	-	0.18

40	Сүхбаатар	ЕБС-1	1.86	-	1.86
41	Сүхбаатар	ЕБС-2	0.27	-	0.27
42	Сүхбаатар	ЕБС-3	0.93	-	0.93
43	Сүхбаатар	ЕБС-4	0.13	-	0.13
44	Сүхбаатар	ЕБС-5	0.64	-	0.64
45	Сүхбаатар	Спорт сургууль	0.22	-	0.22
46	Хушаат	Хүүхдийн цэцэрлэг	1.59	-	1.59
47	Хушаат	ЕБС	0.97	-	0.97
48	Хүдэр	Хүүхдийн цэцэрлэг	0.12	-	0.12
49	Хүдэр	ЕБС	0.15	-	0.15
50	Шаамар	Хүүхдийн цэцэрлэг-1	0.19	-	0.19
51	Шаамар	Хүүхдийн цэцэрлэг-2	0.15	-	0.15
52	Сэлэнгэ шууд	Аймгийн ЗДТГ	-	59.35	59.35
53	Сэлэнгэ шууд	Санхүүгийн хяналт, аудитын алба	0.79	-	0.79
54	Сэлэнгэ шууд	Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сан	9.41	-	9.41
55	Сэлэнгэ шууд	Ардын дуу бүжгийн Сэлэнгийн долгио чуулга	0.29	-	0.29
56	Сэлэнгэ шууд	ГХБХБГазар	0.78	-	0.78
57	ААТҮГ	Сүхбаатар хөгжил тохижилт ААТҮГ	13.84	-	13.84
58	ОНӨААТҮГ	Сэлэнгэ энерго ОНӨААТҮГ	0.35	-	0.35
59	ОНӨААТҮГ	Сэлэнгэ Цэнгэг Ус ОНӨААТҮГ	2.23	-	2.23
60	ОНӨААТҮГ	Гавшгай ус ОНӨААТҮГ	1.29	-	1.29
61	ААТҮГ	Тохилог хараа ААТҮГ	21.03	-	21.03
62	ААТҮГ	Энх мэнд сувилал ААТҮГ	6.43	-	6.43
<b>Нийт дүн</b>			<b>90.09</b>	<b>79.71</b>	<b>169.79</b>